



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/70

Мөрөн сум

Цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийн  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйл 23.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 10 дугаар зүйлийн 10.1.5, аймгийн Боловсролын газрын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын хувийн хөрөнгө оруулалттай “Лидер ХХК-ний дэргэдэх Цовоо” хүүхдийн цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2027 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН